



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 05/03

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 2022 оны төсөв
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Дүүргийн 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

	мянган төгрөгөөр
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	168,658,806.9
I Татварын орлого	164,311,439.4
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	116,621,723.1
Үйл ажиллагааны орлого	2,100,000.0
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	6,700,000.0
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	8,000,000.0
Хадгаламжийн хүүгийн орлого	10,500,000.0
Галт зэвсгийн албан татвар	80,000.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	8,850,000.0
Улсын тэмдэгтийн хураамж	1,000,000.0
Газрын төлбөр	8,159,716.3
Хог хаягдлын хураамж	2,300,000.0
II Татварын бус орлого	4,347,367.5
Хүү, торгуулийн орлого	2,600,000.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	357,700.0
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого	1,389,667.5

Хоёр. Дүүргийн 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

- 1140000020

		мянган төгрөгөөр
№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2	Дүүргийн Засаг дарга	168,658,806.9
2.1	Харьяалах газар, агентлагуудын төсөвт төвлөрүүлэх орлого	166,911,439.4
	Дүүргийн Татварын хэлтэс	166,911,439.4
2.2	Төсөвт байгууллагын өөрийн орлого	357,700.0
	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3,200.0
	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	12,000.0
	Худалдан авах ажиллагааны алба	5,000.0
	Усан спорт сургалтын төв	70,000.0
	Хүүхэд залуучуудын соёлын ордон	120,000.0
	Гэр бүл ёслолын ордон	52,400.0
	Баянгол Агропарк	95,100.0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийн орлого	1,389,667.5

Гурав. Дүүргийн 2022 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 175,135,660.5 мянган төгрөгөөр баталж төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад төсөв зарцуулах эрх олгосугай.

		мянган төгрөгөөр
№	Төсвийн ерөнхийлөн захирагч	
3	Нийт дүн	175,135,660.5
3.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	2,883,702.4
3.1.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2,883,702.4
	Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн үйл ажиллагааны зардал	2,587,702.4
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл	248,500.0
	Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал	27,000.0
	ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	20,500.0
3.2.	Дүүргийн Засаг дарга	172,251,958.1
3.2.1.	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	13,937,938.0
	Үүнээс: Дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн үйл ажиллагааны зардал	7,840,048.0
	Засаг даргын нөөц хөрөнгө	899,500.0
	Хорооны урсгал зардал	4,519,842.0
	Ахмад настны хөгжил хамгаалал	368,684.0
	Улаан загалмайн хөтөлбөр	70,000.0
	Эмэгтэйчүүдийн зөвлөл	38,000.0
	Харуул хамгаалалтын зардал	201,864.0
3.2.2.	Гэрэлтүүлэг тохижилт үйлчилгээний тасаг	10,049,301.8

Үүнээс: Гэрэлтүүлэг тохижилт үйлчилгээний тасгийн үндсэн үйл ажиллагааны зардал	1,597,048.2
Хог хаягдал, орчны бохирдлыг устгах, тээвэрлэх үйлчилгээ	4,387,422.8
Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ	2,724,550.5
Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалт, хамгаалалтын зардал	333,690.0
Нийтийн эзэмшлийн гудамж талбайн камерын ашиглалт, хамгаалалтын зардал	265,450.0
Газар чөлөөлөх зардал	741,140.3
3.2.3. Дотоод аудитын алба	240,396.6
3.2.4. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	197,175.9
3.2.5. Худалдан авах ажиллагааны алба	173,034.0
3.2.6. Усан спорт, сургалтын төв	390,526.1
3.2.7. Баянгол хүүхдийн зуслан	111,732.2
3.2.8. Хүүхэд залуучуудын соёлын ордон	617,604.6
3.2.9. Баянгол Агропарк	993,766.3
3.2.10. Гэр бүл ёслолын ордон	289,939.6
3.2.11. Орон нутгийн өмчийн байр ашиглалтын үйлчилгээний зардал	5,219,000.0
3.2.12. Орон нутгийн өмчийн байр ашиглалтын тогтмол зардал	3,823,634.0
3.2.13. Дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт шилжүүлэх орлого	121,967,112.3
3.2.14. Хөрөнгийн зардал	14,240,796.7
Үүнээс: Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	12,851,129.2
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээ	1,389,667.5

Дөрөв. Дүүргийн 2022 оны төсвийн жилд Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 4,950,000.0 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 1,151,942.1 мянган төгрөгөөр, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 7,901,129.2 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 237,725.4 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Тав. 2022 оны төсвийн жилд дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 121,967,112.3 мянган төгрөгөөр баталсугай.

1. Дүүргийн татварын болон татварын бус орлого 166,911,439.4 мянган төгрөг
2. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 1,389,667.5 мянган төгрөг
3. Дүүргийн төсвийн урьд оны үлдэгдэл 6,476,853.6 мянган төгрөг
4. Дүүргийн төсвийн байгууллагын өөрийн орлого 357,700.0 мянган төгрөг

Долоо. "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Найм. "Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Ес. "Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Арав. "Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалт"-ыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

Арван нэг. "Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021-2022 он дамжин санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалт"-ыг тавдугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА



Б.СӨМЖИДМАА

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17 ны өдрийн 05/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР,
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ТОО БОЛОН
ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

мянган төгрөгөөр

Д/д	Төсвийн эрх захирагчийн нэр, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв
		Чанар	Тоо	
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга			2,883,702.4
1.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	ИТХ-ын чиг үүргийг цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэх.	Дүүргийн ИТХ-ын ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг товлосон хугацаанд багтаан хуралдаж, хэлэлцэх асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.	2,608,202.4
1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллана.	248,500.0
1.3	Гамшгаас хамгаалах арга хэмжээ	Гамшиг, осол, байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.	Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг санхүүжүүлнэ.	27,000.0
2	Дүүргийн Засаг дарга			172,251,958.1
2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд ажиллана.	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлэх, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглах, төрийн албан хаагчийн	136,975,054.8

			мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, тэгш, нээлттэй хүргэнэ.	
2.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Гамшиг, осол, байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд холбогдох хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.	Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан дүүргийн "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг, журмын хүрээнд Засаг даргын нөөц хөрөнгийг төлөвлөн зарцуулна.	899,500.0
2.3	Хот байгуулалт, тохижилт	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ арчилгаа	Дүүргийн нутаг дэвсгэрийн хог хаягдал, орчны бохирдлыг устгах, тээвэрлэх үйлчилгээг гүйцэтгэнэ.	4,387,422.8
2.4	Хот байгуулалт, тохижилт	Хот тохижуулах үйл ажиллагааны хөтөлбөр арга, хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.	Дүүргийн бүх хороодын айл өрх, ААН-үүд, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, хогийн цэгт хүргэх, хот тохижилтын үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	2,724,550.5
2.5	Хот байгуулалт, тохижилт	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалт, хамгаалалтын зардал	333,690.0
2.6	Хот байгуулалт, тохижилт	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хяналтын камер	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн 413 ш камерын ашиглалт, хамгаалалтын зардлыг санхүүжүүлнэ.	265,450.0
2.7	Ахмад настны хөгжил хамгаалал	Дүүргийн ахмадын хорооны үйл ажиллагааг санхүүжүүлэх	Дүүргийн ахмадын хорооны үйл ажиллагаанд зарцуулагдана.	368,684.0

2.8	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	Дүүргийн төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн дотоод хяналтын үйл ажиллагааг хянах	Дотоод аудитын албаны үйл ажиллагааг санхүүжүүлэн ажиллана.	240,396.6
2.9	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа хамаарна.	Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, сурталчлах, үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг худалдааны төвд худалдаа хийх боломжийг нэмэгдүүлнэ.	197,175.9
2.1	Худалдан авах ажиллагаа	Худалдан авах ажиллагаа ил тод, хуулийн хүрээнд зохион байгуулагдана.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлнэ.	173,034.0
2.11	Биеийн тамир спорт	Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ.	390,526.1
2.12	Хүүхдийн хөгжил, хамгаалал	Орон нутгийн төсөвт хүүхдийн хөгжил хамгааллын үйл ажиллагаа явуулдаг газруудыг санхүүжүүлэх	Хүүхэд залуучуудын соёлын ордон, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны зардлуудыг санхүүжүүлэх	729,336.8
2.13	Иргэдэд экологийн боловсрол олгох орон нутгийн ногоон байгууламж нэмэгдүүлэх	Иргэдэд экологийн боловсрол олгох орон нутагт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод сөөг, цэцэг, нарийн ногоо үрслүүлэх чиглэлээрх үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	Агропаркын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлнэ.	993,766.3
2.14	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	Гэр бүл батлуулах, тангараг өргөх, иргэний андгай өргөх гэх мэт гэр бүлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	Дүүргийн гэр бүл ёслолын ордны үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	289,939.6

2.15	Орон нутгийн гүйцэтгэх засаглал, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, биеийн тамир спорт хорооны төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг санхүүжүүлэх	Ерөнхий боловсролын сургуулийн 19 байгууллага, шинээр ажиглалтад орох ашиглалтад 3 өргөтгөл, Албан бус насан туршийн боловсролын төв 1, цэцэрлэг-37, шинээр ашиглалтад орох 2, өргөтгөл 2 цэцэрлэгүүдийн байр ашиглалтын үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.	5,219,000.0
2.16		Орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэг, биеийн тамир спорт хорооны байр ашиглалтын тогтмол зардлыг санхүүжүүлэх	Ерөнхий боловсролын сургуулийн 19 байгууллага, Албан бус насан туршийн боловсролын төв 1, цэцэрлэг-37, шинээр ашиглалтад орох 2 нийт 49 байгууллагын байр ашиглалтын тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	3,823,634.0
2.17	Орон нутгийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.	Орон нутгийн болон иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн саналын хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.	12,851,129.2
2.18	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.	Дүүргийн 25 хорооны иргэдээс ирүүлсэн саналын хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1,389,667.5
Нийт дүн				175,135,660.5

---ooo000ooo---

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 17 ны өдрийн 05/03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2022 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

мянган төгрөгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр	Байршил	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Түшиц хана засварлах ажил	19-р хороо	2022	490,000.0	490,000.0
2	Орчны тохижилт /гэр хороолол/	9, 10, 11, 21-р хороо	2022	400,000.0	400,000.0
3	Орчны тохижилт	23-р хороо	2022	200,000.0	200,000.0
4	Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт	17, 18, 19-р хороо	2022	400,000.0	400,000.0
5	Н.Цэрэнноровын гудамжны тохижилт	1, 3, 4-р хороо	2022	200,000.0	200,000.0
6	Орчны тохижилт	5, 6, 7, 8	2022	350,000.0	350,000.0
7	Орчны тохижилт	13, 14, 15	2022	300,000.0	300,000.0
8	Тохижилт бүтээн байгуулалтын ажил	16	2022	100,000.0	100,000.0
9	Тоглоомын талбай байгуулах	20	2022	100,000.0	100,000.0
10	Тоглоомын талбай байгуулах	2, 3, 12	2022	250,000.0	250,000.0
11	Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт	-	2022	800,000.0	800,000.0
12	Хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийх, траншейны таг солих ажил	1-8, 12-20, 24, 25-р хороо	2022	150,000.0	150,000.0
13	Явган хүний гүүр барих	9-11, 16, 21-23-р хороо	2022	150,000.0	150,000.0
14	Архивын барилгын инженерийн шугам сүлжээ	20-р хороо	2022	800,000.0	800,000.0

15	11, 12 дугаар байрны урд талын авто замын авто замын зорчих хэсэгт орсон дулаан цэвэр усны шугамын худгийн таг солих	4-р хороо	2022	60,000.0	60,000.0
16	Ногоон байгууламжийн усалгааны авто машин, тоног төхөөрөмж	-	2022	200,000.0	200,000.0
	НИЙТ ДҮН			4,950,000.0	4,950,000.0

---ooo000ooo---

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 202...1... оны...1... дугаар сарын... нь өдрийн ...05/03... дугаар тогтоолын гуравдугаар хавсралт



**ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
2022 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЖАГСААЛТ**

мянган төгрөгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Камержуулалт /3, 5, 9-р хороо/	2022	112,450.0	112,450.0
2	Дээвэр засвар /1, 7, 12, 15, 17,18,19-р хороо/	2022	365,100.0	365,100.0
3	Дээвэр засвар, орчы тохижилт /20-р хороо/	2022	56,200.0	56,200.0
4	Хог хаягдал ангилан ялгах сав байршуулах ажил /2,4,6,23-р хороо/	2022	196,640.0	196,640.0
5	Тоглоомын талбай тохижуулах /8,24-р хороо/	2022	84,330.0	84,330.0
6	Орчны тохижилтын ажил /11,13-р хороо/	2022	84,280.0	84,280.0
7	Тохижилт бүтээн байгуулалтын ажил /16-р хороо/	2022	56,200.0	56,200.0
8	Гэрэлтүүлэг /25-р хороо/	2022	28,152.0	28,152.0
9	Гэрэлтүүлэг, камержуулалтын ажил /21,22-р хороо/	2022	56,200.1	56,200.1
10	Өрхийн эрүүл мэндийн төвийн засвар тохижилт /10-р хороо/	2022	112,390.0	112,390.0
	НИЙТ ДҮН		1,151,942.1	1,151,942.1

---ooo000ooo---

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 202..... оны..... дугаар сарын..... ны өдрийн дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт



**ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2021-2022 ОН ДАМЖИН
САНХҮҮЖИХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

мянган төгрөгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд дамжин санхүүжих
1	Тоглоомын талбайн засвар шинэчлэлтийн ажил /1, 2, 4, 5, 6, 7, 8, 10 дугаар хороо/	2019-2022	416,780.7	10,065.8
2	Зураг төслийн ажил	2019-2022	499,700.0	13,669.5
3	Зураг төслийн ажил	2019-2022	50,000.0	2,500.0
4	Явган зорчигчийн гүүрэн гарц байгуулах ажлын зураг төсөв /Нарны хорооллоос нарны зам руу төмөр зам дээгүүр гарсан гүүрэн гарц, Алтай хотхоны зүүн талын автобусны буудлаас Нарны хорооллын баруун талын автобусны буудал руу гарсан гүүрэн гарц /	2021-2022	120,000.0	120,000.0
5	Явган зорчигчийн гүүр засварлах ажлын зураг төсөв /Барсын гүүр/	2021-2022	20,000.0	20,000.0
6	Тохижилт бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв	2021-2022	160,000.0	160,000.0
7	Ерөнхий боловсролын сургууль, шаардлагатай засвар, тохижилт	2021-2022	14,500.0	14,500.0
8	Цэцэрлэгүүдэд шаардлагатай засвар тохижилт	2021-2022	16,000.0	16,000.0
9	Цэцэрлэгүүдэд шаардлагатай сантехникийн засвар	2021-2022	19,500.0	19,500.0
10	Баянгол дүүргийн Татварын хэлтсийн барилгын дулаалга	2021-2022	20,000.0	20,000.0
11	Дүүргийн түрээсийн орон сууцны барилгын ажил	2021-2022	5,500,000.0	25,000.0
12	Орчны тохижилт бүхий хог хаягдал ангилан ялгах цэг байгуулах /Нийтийн эзэмшлийн зам талбай/	2021-2022	20,000.0	3,942.6

13	Бичил тохижилтын ажил /Үүсмэл хогийн цэг/ 9, 21 дүгээр хороо	2021-2022	20,000.0	6,047.2
14	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат засварлах ажил / 2, 7,18 дугаар хороо/	2021-2022	116,000.0	116,000.0
15	Нийтийн зориулалттай орон сууцны орцны засвар / 1, 3, 10 дугаар хороо/	2021-2022	54,000.0	26,826.5
16	Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ-ын хог тээврийн автомашин худалдан авах ажил	2021-2022	750,000.0	264,790.0
17	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах /14 дүгээр хороо 15 дугаар байрны урд/	2021-2022	120,000.0	32,433.0
18	Авто зам, явган хүний зам засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөв	2021-2022	266,000.0	266,000.0
19	Хүүхдийн зуслангийн гадна талбайн тохижилтын ажил	2021-2022	154,100.0	154,100.0
20	Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн барилгын засварын ажил	2021-2022	170,000.0	32,901.0
21	Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газар, хороодын тохижилт	2021-2022	100,000.0	100,000.0
22	Хог тээврийн тусгай зориулалтын авто машин	2021-2022	1,500,000.0	1,500,000.0
23	Явган хүний зам 1-6, 24, 25 дугаар хороо /нийтийн эзэмшлийн зам талбайд/	2021-2022	450,000.0	450,000.0
24	Явган хүний зам 7, 8, 12-15, 17, 18, 19 дүгээр хороо /нийтийн эзэмшлийн зам талбайд/	2021-2022	427,000.0	427,000.0
25	25-н хороо, иргэдэд үйлчлэх төв, дэргэдэх байгууллагуудад тоног төхөөрөмж авах	2021-2022	500,000.0	500,000.0
26	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засвар	2021-2022	500,000.0	500,000.0
27	Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэл	2021-2022	500,000.0	500,000.0
28	Нийтийн эзэмшлийн зам талбайн Гэрэлтүүлэг суурилуулах ажил	2021-2022	665,000.0	665,000.0
29	Тохижилт, бүтээн байгуулалтын ажил	2021-2022	300,000.0	300,000.0
30	Орчны тохижилт /9 дүгээр хороо 146 дугаар сургууль орчим/	2021-2022	200,000.0	200,000.0
31	Орчны тохижилт /21 дүгээр хороо 278 дугаар цэцэрлэг орчим/	2021-2022	200,000.0	200,000.0

32	Авто зогсоол байгуулах /Баянгол Агропарк ОНӨТҮГ/	2021-2022	750,000.0	750,000.0
33	"Баянгол Агропарк" ОНӨТҮГ-т сургалтын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах	2021-2022	189,853.6	189,853.6
34	Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын зураг, төсөв /Баянгол Агропарк ОНӨТҮГ/	2021-2022	120,000.0	120,000.0
35	Дүүргийн онцгой комисс, онцгой байдлын албаны хэрэгцээнд шаардлагатай авто машин худалдаж авах	2021-2022	100,000.0	100,000.0
36	Эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж	2021-2022	75,000.0	75,000.0
	Нийт дүн		15,083,434.3	7,901,129.2

---ooo000ooo---

Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 27 ны өдрийн 05/03 дугаар тогтоолын тавдугаар хавсралт



**ДҮҮРГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2021-2022 ОН ДАМЖИН САНХҮҮЖИХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

мянган төгрөгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Хүүхдийн тоглоом, спорт талбайн тохижилтын ажил	2021	200,000.0	99,125.2
2	Орон сууц, гэр хорооллын камержуулалтын ажил	2021	112,000.0	48,237.1
3	Орон сууц, гэр хороололд гэрэлтүүлэг суурилуулах ажил	2021	150,000.0	51,034.0
4	Нийтийн эзэмшлийн зам талбайн Гэрэлтүүлэг суурилуулах ажил	2021	74,544.0	39,329.1
	НИЙТ ДҮН		536,544.0	237,725.4

---ooo000ooo---